

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ДАРГА Э.БАТТУЛГА

2020 оны 06 дугаар сарын 09-ны өдөр

УОА0033 9077049

**ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЗ ЗУРВАС СЭРГЭЭХ АЖИЛ ЯВУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Түймрээс хамгаалах халз зурвас сэргээх ажил явуулах

Төслийн дугаар: НБОГ-20/005

Улаанбаатар хот

## ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 80’000’000 хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар шалгаруулахад мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн ажлыг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах ажил буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Нийслэлийн Байгаль орчны газар**нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **НБОГ-20/005** дугаартай **Түймрээс хамгаалах халз зурвас сэргээх ажил явуулах** ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 11 цаг 00 минут**-аас өмнө Цахим худалдан авах ажиллагааны систем (**tender.gov.mn**)-ээр ирүүлнэ.

Тендерийн нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 06 дугаар сарын 18-ны/ний өдрийн 12 цаг 00 минут**-д нээнэ.

Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем (**www.tender.gov.mn**) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50.000** /тавин мянга/ төгрөгийг **www.tender.gov.mn**-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Нийслэлийн Байгаль орчны газар, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-7/1,  
Нийслэлийн Засаг Захиргааны II байр,  
Хангарди ордон, 4 давхар 406 тоот, Утас: 318003**

**[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
    - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1.1 Сүүлийн <b>2</b> жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт;</p> <p>1.2 Сүүлийн <b>3</b> жилийн аль нэг жилд <b>ижил төстэй ажил</b> эсхүл зам гүүрийн барилга, байгууламжийн ажил гүйцэтгэсэн;</p> <p>1.3 Нэг ажлын өртөг: <b>Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй.</b> /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, ажил хүлээлцсэн акт, комисст хүлээлгэн өгсөн акт, албан бичиг зэргийн хуулбар/;</p> <p>1.4 Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: сүүлийн 3 жил /ирүүлэх боломжгүй тохиолдолд үндэслэлийг тодорхойлж, албан бичиг ирүүлэх/</p> <p>1.5 Сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 оны аль нэг жилд борлуулалтын орлого: <b>Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй.</b></p> <p>1.6 Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажил төрөлтэй дүйцэх ажил дээр ажилласан байх хугацаа: <b>3 жил.</b></p> <p>1.7 Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: <b>2 жил.</b></p> <p><b>ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮД ДАРААХ НЭМЭЛТ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙХ ЁСТОЙ. ҮҮНД:</b></p> <p>2.1 Түншлэлийн гишүүн тус бүр энэхүү ТӨӨЗ-ний 5.2-т заасан шаардлагуудыг хангасан байх шаардлагатай. Түншлэлийн гэрээг хавсаргах, түншлэгч тус бүрийн гүйцэтгэх ажлыг тодорхой тусгах.</p> <p>2.2 Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: <b>Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй.</b></p> <p>2.3 Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлнээс гадна дараах хэл дээр байна. Үүнд: <b>Гадаадын этгээд оролцох боломжгүй.</b></p> <p>2.4 Хувилбарт тендер ирүүлэхийг: <b>“зөвшөөрөхгүй”</b></p> <p>2.5 Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“тохируулахгүй тогтмол байна.”</b></p> <p>2.6 Тендер нээснээс хойш <b>45</b> хоногийн туршид хүчинтэй байна.</p> <p>2.7 Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>“тооцно”</b> Жич: Тендерт оролцогч албан хүсэлт, нотлох баримт ирүүлээгүй бол давуу эрх тооцохгүй.</p> <p>2.8 Гүйцэтгэлийн баталгаа: <b>шаардана.</b></p> <p>2.9 <b>ТБОНӨХБАҮХА</b> тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдэгдэнэ.</p> <p>2.10 <b>ТБОНӨХБАҮХА</b> тухай хуулийн 14.7-д заасан хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг бичгээр ирүүлнэ. (Өөр орон нутагт болон тухайн орон нутагт) үнэн зөв мэдээлэл ирүүлэх шаардлагатай.</p> <p>2.11 Тендерт оролцогч нь өөр орон нутагт ижил төрлийн ажил гүйцэтгэж байгаа бол тус ажлыг гүйцэтгэх инженер, техникийн ажилтнууд,</p>

машин, техникийн чадавхийг давхцуулахгүйгээр санал болгосон тендерт ирүүлнэ. (хэрэв бусад тендерүүдэд санал болгосон инженер, техникийн ажилтнууд, машин, техник давхацсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.)

**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТУХАЙН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ДАРААХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙХ ШААРДЛАГАТАЙ.ҮҮНД:**

3.1 БОНХ-ийн сайдын 2013 оны А/223-р тушаалаар батлагдсан “Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам”-ын 2.3. -д заасан “Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх” тусгай зөвшөөрөлтэй байх

3.2. Зам, тээврийн хөгжлийн яамны “2.8.8 Зам, замын байгууламжид хамаарах талбай барих, засварлах” тусгай зөвшөөрөлтэй байх

**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТУХАЙН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ДАРААХ НЭМЭЛТ МАТЕРИАЛЫГ ӨӨРИЙН ТЕНДЕРТ ИРҮҮЛНЭ. ҮҮНД:**

4.1 Тендер Монгол хэл дээр байна. Гадаад хэл дээр ирүүлсэн бүх материалыг орчуулж баталгаажуулсан байна.

4.2 Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ.

4.3 Татварын газрын цахим тодорхойлолт /дутуу төлөлт 0 байх, эх хувь/

4.4 Харьяа Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ.

4.5 Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлнэ.

4.6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.

4.7 Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг Улсын бүртгэлийн гэрчилгээний заалт бүрээр ирүүлнэ

4.8 Үнийн санал (Үнийн саналын маягтын дагуу)

4.9 Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн нотариатаар баталгаажуулсан хуулбар, тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ.

4.10 Инженер техникийн ажилчдын жагсаалт, диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар

4.12 Үндсэн ажилтан болох ИТА-дын нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар, шилжилт хөдөлгөөн хийгдсэн бол шилжилт хөдөлгөөн хийгдсэн хуулбар.

4.13 Өөрийн харьяа нийгмийн даатгалын байгууллагаас нийт ажилтан, ажиллагсадын тоо, сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн даатгуулагч болон ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай лавлагааг ирүүлэх.

4.14 Төсвийн задаргаа ирүүлэх ба Байгаль орчин ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-368/302 дугаартай тушаалыг баримтлан тооцно. (Төсвийг нормативын дагуу тооцох ба үндэслэлгүйгээр бууруулахгүй байх, бууруулсан тохиолдолд үндэслэлийн тайлбарлан хамт ирүүлэх).

	<p><b>ДАРААХ ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦААНД (ӨӨРИЙН, ТҮРЭЭСЛЭХ, ХӨЛСЛӨН АВАХ Г.М.) БЭЛЭН БАЙЛГАХ ШААРДЛАГАТАЙ. ҮҮНД:</b></p> <p>5.1 Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар ирүүлнэ. Хэрэв түрээслэх бол түрээсний гэрээний хуулбарыг баталгаажуулан ирүүлэх</p> <p>5.2 Тендерт оролцогч өөрийн байгууллагын баланст бүртгэлтэй техник тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг ирүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Техникийн тодорхойлолт хэсэгт хавсаргасан ажлын даалгаврын дагуу тоног төхөөрөмж, машин механизмын мэдээллийг ирүүлнэ.</li> </ul> <p>5.3 Ажлын гүйцэтгэлд чанарын зөрчил, гологдол гарсан тохиолдолд түүнийг засах, залруулах тухай шаардлага өгөхөд үл маргалдах журмаар биелүүлэхийг зөвшөөрч байгаа талаарх аж ахуйн нэгж байгууллагын албан бичиг, тодорхойлолт</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж <b>50,000/тавин мянга/ төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр</b> банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.</p> <p>Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 18-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>
<p>ТӨӨЗ 2.2</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Чингэлтэй дүүрэг. Ц.Жигжиджавын гудамж-9. Нийслэлийн Засаг захиргааны 2 дугаар байр</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Нийслэлийн Байгаль орчны газар, 406 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 06 дугаар сарын 18-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>12 цаг 30 минут</b></p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<b>Багцгүй.</b></p>



Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


  
 БАТЛАВ  
 НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
 ГАЗРЫН ДАРГА  
 Э.БАТТУЛГА  
 2020 оны ... дугаар сарын ... өдөр

**ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЗ ЗУРВАС СЭРГЭЭХ АЖИЛ  
ГҮЙЦЭТГЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БҮСЭД ОЙН ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЗ ЗУРВАС СЭРГЭЭХ АЖЛЫН АГУУЛГА	Улаанбаатар хотын ногоон бүсийн заагдсан газруудад нийт 40 м өргөн 2 км урт ойн зурвас сэргээнэ.																															
БЭЛТГЭЛ АЖИЛ	1. Халз зурвас болон харлуулсан зурвасыг байгуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмжийг бэлтгэх 2. Халз зурвасыг байгуулах технологийн картыг боловсруулж захиалагчаар батлуулах 3. Халз зурвасыг байгуулах газрууд дахь өсвөр насны модыг шилжүүлэн тарих бэлтгэл ажлыг хангах, шилжүүлэн тарих Үүнд: Бага баянгийн амны хуучин зурвасаас 0,7 метрийн өндөртэй шилмүүст зулган мод орно. 4. Халз зурвас болон харлуулсан зурвасыг байгуулах газруудад модыг огтлох, хожуулыг зайлуулах бригадыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулна. Үүнд: - Бригадын дарга 1 - Хөрөөчин 1 - Туслах хөрөөчин 1 - Тракторын оператор 1 - Осорлогч 2 - Ачигч 4 - Жолооч 2 5. Зурвас гаргах шаардлагатай бүх талбайнуудын хилийг тогтоож, зургийг гаргах, хилийн шонг хийж, талбай тусгаарлах 6. Зурвас гаргах чиглэлүүдийг тогтоож цагаалах зам, ачих талбарыг бэлтгэх 7. Тээврийн машины зам, гүүр гаргах																															
ХАЛЗ ЗУРВАС БАЙГУУЛАХ	Халз зурвас: сэргээх байршлууд: <table border="1" data-bbox="662 1422 1324 1807" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Халз зурвас байгуулах газрын нэр, чиглэл</th> <th rowspan="2">Хэсэглэлийн дугаар</th> <th rowspan="2">Ялгарлын дугаар</th> <th colspan="2">Халз зурвасын хэмжээ (метрээр)</th> </tr> <tr> <th>Урт</th> <th>Өргөн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Бага аяангаас Халз нгийн ам руу чиглэсэн зурвас</td> <td>23</td> <td>10</td> <td>600</td> <td>40</td> </tr> <tr> <td>2</td> <td>Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Шарга морьтын эхнээс зүүн хойш чиглэсэн зурвас</td> <td>88</td> <td>11</td> <td>1400</td> <td>40</td> </tr> <tr> <td colspan="4" style="text-align: center;">Нийт</td> <td>2000</td> <td>40</td> </tr> </tbody> </table>						№	Халз зурвас байгуулах газрын нэр, чиглэл	Хэсэглэлийн дугаар	Ялгарлын дугаар	Халз зурвасын хэмжээ (метрээр)		Урт	Өргөн	1	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Бага аяангаас Халз нгийн ам руу чиглэсэн зурвас	23	10	600	40	2	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Шарга морьтын эхнээс зүүн хойш чиглэсэн зурвас	88	11	1400	40	Нийт				2000	40
№	Халз зурвас байгуулах газрын нэр, чиглэл	Хэсэглэлийн дугаар	Ялгарлын дугаар	Халз зурвасын хэмжээ (метрээр)																												
				Урт	Өргөн																											
1	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Бага аяангаас Халз нгийн ам руу чиглэсэн зурвас	23	10	600	40																											
2	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Шарга морьтын эхнээс зүүн хойш чиглэсэн зурвас	88	11	1400	40																											
Нийт				2000	40																											

	<p>&gt; Халз зурвас сэргээх явцад тайланг өргөн мэднэ хэмжээг тооцож, ойн нөөц ашигласны төлбөрийг талж "Эрхийн бичиг" авна.</p>
<p>ТАЙЛАН БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ</p>	<p>Халз зурвас сэргээх ажлын тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайланг дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Халз зурвасыг сэргээх талбайн зураг 1:50000 масштабаар хийж ирүүлнэ.</li> <li>2. Халз зурвасыг сэргээх талбайн ой эзхион байгуулалтын зураг буулгаж ирүүлнэ.</li> <li>3. Халз зурвасыг байгуулах ажлын гүйцэтгэл.</li> </ol> <p>Тайланг захиалагч байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн авна.</p> <p>Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сулсааныг Балтийн тэнгэрийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зургалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусламжийг харгалзан.</p> <p>Ажлын тайлан болон зургийн шр.файлуудыг цахим хэлбэрээр JCD, DVD/1 хувь ирүүлнэ.</p>
<p>ХАЛЗ ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖИЛД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Цахилсан хэрэг</li> <li>2. Анонж ПКЛ-70А, ПКЛ-70Д асвал түүнтэй дүйцэх</li> <li>3. Хөмрүүтэгчтэй ПЛ-1-1 анонж асвал түүнтэй дүйцэх</li> <li>4. Ерөнхий зориулалтын анонж ПЛН 3-35, ПЛН 4-35, ПЛН 6-35 асвал түүнтэй дүйцэх</li> <li>5. Суваг талач ПЛН-55 асвал түүнтэй дүйцэх</li> <li>6. Мэд. газарийн автомашин: ЗИЛ-131, УРАЛ-475, КАМАЗ болон адгартай дүйцэхүйц бартай туулах чадвартай өнцөг автомашин</li> <li>7. Эскавалтор асвал түүнтэй дүйцэх 60 км хөдөлгүүрийн хүчин чадалтай эскавалтор</li> </ol>
<p>МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР АЖИЛЦАД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	<p>Халз зурвасыг байгуулахад шаардлагатай ойн аж ахуйн, ойн инженер техникийн болон утрын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:</p> <p>Ерөнхий инженер нь ойн аж ахуйн болон ойн инженерийн мэргэжилтэн байх. Ойн туймраас хамгаалах халз зурвас байгуулах ажил буюу гэрээгээр зөвшөөрж ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ажил төслэй ажил гүйцэтгэсэн 5 жилийн туршилагатай байх, түүний дотор гэрээг бие даан хариуцаж ажилласан 3 хуртай жилийн туршилагатай байх.</p> <p>Инженер техникийн ажилтан ойн инженерийн мэргэжилтэй байх. Ойн туймраас хамгаалах халз зурвас байгуулах ажил буюу гэрээгээр зөвшөөрж ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ажил гүйцэтгэсэн 3 хуртай жилийн туршилагатай байх.</p> <p>Халз зурвас болон харлуулсан зурвасыг байгуулахад шаардлагатай тусламж харгалслийн ажилтныг, үйлчилгээний ажлыг бие даан гүйцэтгэх мэргэжилтэн чадвартай байх.</p> <p>Угирлын ажилчид нь өөрийн хариуцсан техник, харгалслийг ашиглах чадвартай мэргэжилтэн үнэмлэх болон зарлагатай байх, жижигмөр хангаалах, ажилтныг ажиллагааны явцад чадвартай байх гэж өөрийн гэгээн дагалд хийгээсэн байх.</p>

Ойн туйвраас хамгаалах хэлт зурвасыг байгуулах ахуйг зохион байгуулахад шаардлагатай туслах ажлынхдаа төлөгч, жолооч гэх мэт байх

ХЯНАСАН:



Б.БОЛОРТУЯА  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ГАЗРЫН ОЙН ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:



Ч.ДАМБАСҮРЭН  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ГАЗРЫН ОЙН ХЭЛТСИЙН  
АХУАХ МЭРГЭЖИЛТЭН

**Тав. ЗУРАГ**

<b>Зураг төслийн жагсаалт</b>		
<b>Д/д</b>	<b>Зураг төслийн нэр</b>	<b>Агуулга</b>
1.	Халз зурвас сэргээх талбайн зураг	Халз зурвасыг байгуулахад шаардлагатай 1:120 000 масштабтай ойн сангийн тархалтын зураг, ой зохион байгуулалтын зураг, газрын ландшафтын зураг
2.	Халз зурвас сэргээхэд шаардлагатай техник хэрэгсэлийн зураг	Техникийн байдал, ашиглалтыг ойлгомжтой харуулсан гэрэл зураг

**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

<b>№</b>	<b>Ажлын нэр, тодорхойлолт</b>	<b>Гүйцэтгэх хугацаа</b>
1	Бэлтгэл ажлыг хангах шат	2020 оны 06 дугаар сарын 25-ноос 2020 оны 06 дугаар сарын 30-ныг хүртэл
2	Халз зурвасыг байгуулах ажлын шат	2020 оны 06 дугаар сарын 30-наас 2020 оны 07 дугаар сарын 20-ныг хүртэл
3	Тайлан боловсруулалтын шат	2020 оны 07 дугаар сарын 20-наас 2020 оны 8 дугаар сарын 05-ний өдрийг хүртэл
4	Эцсийн тайланг хүлээн авах	2020 оны 08 дугаар сарын 10

**Долоо. ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНИЙ ХУВААРЬ**

№	Ажлын нэр	Ерөнхий инженер	Бригадын дарга	Хөрөөчин	Туслах хөрөөчин	Тракторын оператор	Оосорлогч	Ачигч	Жолооч
1	Бэлтгэл ажил	<ol style="list-style-type: none"> <li>Төслийг удирдан зохион байгуулах</li> <li>Халз зурвасыг сэргээхэд шаардлагатай техник тоног төхөөрөмжийг бэлтгэх</li> <li>Халз зурвасыг сэргээхэд шаардлагатай зурвасыг модыг огтлох, цагаалах, шилжүүлэн суулгах технологийн картыг хийх</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Бригадыг байгуулах</li> <li>Зурвас гаргах талбайнуудын хилийг тогтоож, зураглал гаргах, хилийн шонг байрлуулах</li> <li>Зурвас гаргах чиглэлүүдийг тогтоож цагаалах зам, ачих талбарыг бэлтгэх</li> <li>Ашиглаж буй техник хэрэгсэлийн ашиглалт, үйлчилгээг хариуцах</li> </ol>		<ol style="list-style-type: none"> <li>Халз зурвасыг сэргээх газруудад өсвөр залуу модыг шилжүүлэх.</li> <li>Халз зурвасыг сэргээх газруудад модыг огтлох, хожуулыг зайлуулах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Халз зурвасыг сэргээх, огтолсон модны хожуулыг зайлуулах</li> <li>Шилжүүлэн суулгах өсвөр насны модыг бэлтгэх, Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Халз зурвасыг сэргээх огтолсон модыг цагаалагын тракторд бэхлэх Шилжүүлэн суулгах өсвөр модыг ачиж тээвэрлэхэд бэлтгэх</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Огтолсон болон шилжүүлэн суулгаж байгаа модыг тээвэрлэх</li> </ol>	
2	Халз зурвас байгуулах ажил	<ol style="list-style-type: none"> <li>Шилжүүлэн суулгах өсвөр насны модыг зөөвөрлөж тарих</li> <li>Халз зурвас сэргээх ажилд өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Халз зурвасыг сэргээх ажлыг гардан зохион байгуулж өдөр тутмын удирдлагаар ханган ажиллах.</li> <li>Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хянах</li> <li>Халз зурвас сэргээх технологийн картыг мөрдөж ажиллах</li> </ol>		<ol style="list-style-type: none"> <li>Огтолж бэлтгэсэн модыг цагаалах, Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Халз зурвасыг сэргээх</li> <li>Техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцах</li> </ol>			

Тайлбар: Гэрээ байгуулагдах үед голлох мэргэжилтнүүдийн хуваарьт өөрчлөлт оруулж болно.

Долоо.ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат   |

хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 13.2. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 14. Хүлээж авах**
- 14.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 15. Эцсийн тооцоо**
- 15.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт



өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**16. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**

16.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

16.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

**17. Гэрээг цуцлах**

17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**18. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: [Түймрээс хамгаалах халз зурвас сэргээх ажил явуулах, НБОГ-20/005]
ГЕН 2.1	Ажил нь [Улаанбаатар хотын ногоон бүсэд ойн түймрээс хамгаалах халз зурвас сэргээх ажил]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Бага баянгаас Халзангийн ам руу чиглэсэн зурвас.
ГЕН 3.1	Төслийн менежер нь [Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-9, Нийслэлийн Засаг захиргааны 2 дугаар байр, 4 давхар, 406 тоот]
ГЕН 4.1	Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Бэлтгэл ажил: 2020 оны 06 дугаар сарын 30 Халз зурвасыг байгуулах ажил: 2020 оны 07 дугаар сарын 20 Тайлан боловсруулах, хүлээлгэн өгөх 2020 оны 08 дугаар сарын 10
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа [60 хоног] байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0%] байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [0%] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Халз зурвасыг сэргээх талбайн мэдээлэл, гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актыг 2020 оны 07 дүгээр сарын 09-ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [нийт үнийн дүнгийн 0%] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [0%]-иар тооцно.

### Гэрээний тусгай нөхцөлийн нэмэлт:

- Урьдчилгаа төлбөрийн дүн нь: Гэрээ байгуулсны дараа гэрээний үнийн дүнгийн 50 %-ийг олгох, ажлын үр дүнг тогтоон актаар хүлээн авсны дараа үлдэгдэл 50%-ийг санхүүжүүлнэ.
- Ажлын хөтөлбөрийг 14 хоног тутам тодотгоно.
- Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын доод хэмжээг гүйцэтгэгч хариуцна.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт / гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана,

\_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]